



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/72

Есөнбулаг сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9, 32.1.10 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 109 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.17 дугаар жарны "Сүрээр дарагч" хэмээх улаан морин жилийн сар шинийн баяр, амралтын өдрүүдэд аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Аймгийн цахилгаан, усан хангамж, сумдын болон онцгой объектуудын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах аймгийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, жижүүрийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Аймаг, сумдын удирдлага, ард иргэдэд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол хүргэж, сумдын онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ц.Лувсанжамц), Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Н.Алтантуяа)-д тус тус даалгасугай.

4.Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийг амгалан тайван байх нөхцөлийг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Д.Бүрэнбаатар)-т даалгасугай.

5.Аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих эргүүл, жижүүрийг томилон ажиллуулж, Онцгой байдлын газрын 77480101 тусгай дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг өдөр бүрийн 09:00, 14:00, 20:00 цагт, яаралтай мэдээ, мэдээллийг тухай бүр нь өгч

ажиллахыг сумдын удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6.Сар, шинийн амралтын өдрүүдэд аймгийн хариуцлагатай жижүүрүүд томилгоот хугацаанд аймгийн онц чухал объектыг өдөрт хоёроос доошгүй хугацаанд шалгаж, илэрсэн зөрчил, өгсөн үүрэг даалгаврыг тэмдэглэлээр баталгаажуулж ажиллахыг үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дугаар сарын 04 -ны өдрийн 4 дугаар
захирамжийн хавсралт /72

АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН
АЖИЛЛАХ ХУВААРЬ

Он, сар, өдөр	Ерөнхий жижүүрийн нэрс	Албан тушаал	Жижүүрийн хуваарь	Утсаны дугаар
2026.02.17	Д.Бүрэнбаатар	Цагдаагийн газрын дарга, хурандаа	09:00-09:00	88115839
2026.02.18	Л.Жамбалсүрэн	341 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа	09:00-09:00	88107746
2026.02.19	Л.Хаш-Эрдэнэ	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	09:00-09:00	99072865
2026.02.20	Ч.Батзориг	Улаан загалмайн хорооны дарга	09:00-09:00	99141277
2026.02.21	Ц.Лувсанжамц	Онцгой байдлын газрын дарга, хурандаа	09:00-09:00	88099342
2026.02.22	Ж.Мянганбаяр	Газрын харилцаа, барилга, хот байгууллалтын газрын дарга	09:00-09:00	98116790

---oOo---

۹ .. پس ، پدر (نام) در اینجا در بعضی موارد به جای نام می آید و این کارها هم در اینجا هم
 و همچنین در اینجا هم به جای نام می آید و این کارها هم در اینجا هم به جای نام می آید و این کارها هم
 به جای نام می آید و این کارها هم در اینجا هم به جای نام می آید و این کارها هم در اینجا هم
 به جای نام می آید و این کارها هم در اینجا هم به جای نام می آید و این کارها هم در اینجا هم

۱۰ .. در اینجا در بعضی موارد به جای نام می آید و این کارها هم در اینجا هم به جای نام می آید و این کارها هم
 به جای نام می آید و این کارها هم در اینجا هم به جای نام می آید و این کارها هم در اینجا هم
 به جای نام می آید و این کارها هم در اینجا هم به جای نام می آید و این کارها هم در اینجا هم

نام و نام خانوادگی
 شماره شناسنامه
 تاریخ تولد
 شماره کارت ملی
 شماره پاسپورت